НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР
ИЛТГЭХ ХУУДАС

2023 оны 05 дугаар сарын 25 Улаанбаатар хот

АЯН ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын дэргэдэх Ёс зүйн зөвлөлийн санаачилгаар Төрийн албан хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, чадавхжуулах, тэдний урам зоригийг сэргээх, хариуцлагатай албыг төлөвшүүлэх, ажиллагсдын ёс зүй, харилцаа хандлагыг төлөвшүүлэх зорилго бүхий "Талархал"-ын аян амжилттай өрнөж, дүнгээ гаргалаа.

Тус аяны хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд.

1. Ажлын сахилга, хариуцлагыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд "Цагийн менежменттэй-Эртэч ажилтан" шалгаруулах
2. Ажилтны ёс зүй, харилцаа, хандлагыг сайжруулах зорилтын хүрээнд "Ёс зүйн гомдол хүлээн авах"
3. "Хором бүрийг үнэ цэнэтэй-Үр дүнтэй өнгөрөөцгөөе" зорилтын хүрээнд Уучлалын өдөр
4. "Ёс зүйг эрхэмлэгч хариуцлагатай ажилтан" зорилтын хүрээнд талархлын өдөр
5. Мэдээллийн самбар дахь Ёс зүйн зөвлөл буланд аянтай холбоотой мэдээллийг өдөр бүр шинэчлэв

Ажлын сахилга, хариуцлагыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хэлтэс бүрээс "Цагийн менежменттэй-Эртэч ажилтан" шалгаруулалтад

- Хууль, дотоод хяналтын хэлтсийн Дотоод хяналтын инженер Д.Оюунтуул
- Захиргааны хэлтсийн Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн О.Дэлгэрцэцэг
- Санхүү, аж ахуйн хэлтсийн Хөрөнгө оруулалтын санхүүжилт хариуцсан мэргэжилтэн Э.Лхагважаргал
- Барилга захиалагчийн хэлтсийн Цахилгааны хяналтын инженер Н.Нямдорж
- Зураг төслийн хэлтсийн Зураг төслийн хяналтын инженер Э.Батцэнгэл
- Төлөвлөлт судалгааны хэлтсийн Дарга Н.Эгиймаа
- Мэдээллийн технологийн хэлтсийн Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн Б.Батцэцэг нар шалгарч Зөвлөлийн зүгээс дурсгалын зүйл гардуулав.







Ажилтны ёс зүй, харилцаа, хандлагыг сайжруулах зорилтын хүрээнд "Ёс зүйн гомдол хүлээн авах" саналын хайрцаг ажиллуулан ажилтан, албан хаагчдаас ирүүлсэн саналыг хүлээн авлаа.

"Хором бүрийг үнэ цэнэтэй-Үр дүнтэй өнгөрөөцгөөе" зорилтын хүрээнд Уучлалын, "Ёс зүйг эрхэмлэгч хариуцлагатай ажилтан" зорилтын хүрээнд талархлын өдрүүдэд ажилтан, албан хаагчдаас ирүүлсэн сэтгэгдлийг хүлээн авч, товч танилцуулга хийж, 5 дугаар давхарт нээлттэй байршуулан ажиллав.





Тус Саналын хайрцагт хэн нэгнийг уучилж амжаагүй ажилтан, албан хаагчид, мөн талархаж явдаг чин сэтгэлийн үгсүүдээ Ёс зүйн зөвлөлд бичиж ирүүллээ.



Ажилтан, албан хаагчдаас Ёс зүйн зөвлөлд ирүүлсэн сэтгэгдэлүүд

“Талархал”-ын аяны хүрээнд 5, 6 дугаар давхруудад өдрийг сайхан өнгөрүүлээрэй зураг хуудас байршуулсанд нийт ажилтан, албан хаагчид талархан хүлээн авлаа.





ТАНИЛЦСАН:
ГАЗРЫН ДАРГА Б.МӨНХБАТ

ХЯНАСАН:
МТХ-ИЙНН ДАРГА Х.БАТХҮҮ
ХДХХ-ИЙН ДАРГА Б.БАТБИЛЭГ
СААХ-Н ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.ПҮРЭВЖАВ
ТСХ-Н АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Л.ГАНСҮХ

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:
ЗХ-Н АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН А.СОЛОНГО